



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/225

Мандсговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.3, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/71 тоот тушаалаар батлагдсан "Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого" хийх ажлын удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого" хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Эрдэнэ-Очир (ХОХБТХ-ийн дарга)

Нарийн бичгийн дарга: Н.Гантулга (БОАЖГ-ын дарга)

Гишүүдэд: Б.Рэнцэндорж (ГХБХБГ-ын газрын хэлтсийн дарга)
П.Очирбат (ХОХБТХ-ийн мэргэжилтэн)
Х.Анхбаяр (БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн)
Р.Цэрэндорж (МХГ-ын улсын байцаагч)
Я.Мажаасүрэн (УЦУОШТ-ийн дарга)
Сумдын Засаг дарга нар

Хоёр. Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллогын удирдамжийг хавсралтаар баталсугай.

Гурав. Тооллогыг 2018 оны 5 сарын 29-ны өдрөөс 10 сарын 1-ны өдрийн хооронд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Уг захирамж гарсантай холбогдуулан 2017 оны 6 сарын 27-ны өдрийн А/225 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ



0200692

Аймгийн Засаг даргын 2018 оны
05 дугаар сарын 29-ны өдрийн
тоот захирамжийн хавсралт 2135

УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН ТООЛЛОГО ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл:

2010 онд тус аймгийн Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Өлзийт, Говь угтаал, Баянжаргалан, Гурвансайхан сумдад уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөн эвдэрч орхигдсон нийт 26 газрын 172.98 га талбай бүртгэгдсэн байна.

Үүний 13 газар буюу нийт эвдэрсэн газрын 50 хувь нь жонш, 5 газар буюу 19.2 хувь нь гөлгөний олборлолтоос, үлдсэн 4 газар буюу 30.8 хувь нь нүүрс болон алтны олборлолтоос үүдэн эвдэгдсэн байна.

Мөн аймгийн төв Мандалговиос зүүн тийш 1-3.5 км, урагш 3-5 км-ын зайд 6 хэсэг нийт 86.3 га талбай цэрэг, батлан хамгаалах салбарын зориулалтаар ашиглагдаж, эвдрэлд орж орхигдсон орхигдсон. Уг талбайд нийт 438,230 м³ хог хаягдал үүссэн гэсэн дүгнэлт гарсан.

2010 оноос хойш уул уурхайн ашиглалт, бичил уурхай, хууль бус ашигт малтмал олборлолтоос газрын эвдрэл, доройтол ихэссэн боловч тооллого хийгдээгүйгээс нөхөн сэргээлтийн зардал, байгаль орчны хохирол тооцох, нөхөн сэргээлт хийх ажил тодорхой үр дүнд хүрэхгүй байна.

Хоёр. Ажлын зорилго:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай аймгийн Засаг даргын 2018 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд эвдэрсэн газрын өнөөгийн нөхцөл байдлыг бодитоор тодорхойлж, дүгнэлт хийх, цаашид уул уурхай, ашигт малтмал олборлолтын улмаас эвдрэлд орж, нөхөн сэргээгдэлгүй орхигдсон газарт учирсан хохирлыг тооцох нөхцлийг бүрдүүлэхэд зорилго оршино.

Гурав. Ажлыг удирдан зохион байгуулах болон гүйцэтгэх байгууллага:

- Аймгийн Засаг дарга, ЗДТГазар
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
- Мэргэжлийн хяналтын газар
- Ус цаг уур орчны шинжилгээний газар
- Сумдын Засаг дарга, ЗДТГазар

Дөрөв. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх байгууллага:

- БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар

- МХЕГ-ын Байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын газар
- Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчны мэдээллийн сан

Тав. Хугацаа:

2018 оны 05 дугаар сарын 29-аас 10 дугаар сарын 01

Зургаа. Гүйцэтгэх ажлууд:

Ажлын хэсэг болон холбогдох байгууллагуудын албан тушаалтан:

- Засаг даргын Захирамжаар ажлын хэсэг байгуулах;
- Орон нутгийн төсөв, төлөвлөгөөнд зардлыг тусгуулах;
- Бэлтгэл ажлыг хангах, эвдэрсэн газрын урьдчилсан таңдалт судалгааг сум тус бүрээр гаргах;
- 2018 онд төсөвт тусгагдсан хөрөнгөөр ажлын хэсэг мэргэжлийн түвшинд газар дээр нь шинжилгээ, зураглал, хэмжилт хийн бүртгэх;
- Хөрсний ерөнхий үзүүлэлт болон агергат бүтцийг эвдэрсэн газар бүрт нарийвчлан тодорхойлж, шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид өгч дүгнэлт гаргуулан тайланд тусгах.
- Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагыг татан оролцуулах;
- Тооллогын тайланг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж санал, зөвлөмж гаргах, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан тайланг хүлээлгэн өгөх;
- Тайланг БОАЖЯам, МХЕГ-т хүргүүлэх;
- Тооллогын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, тооллогын үр дүнг мэдээллийн сангаар дамжуулан олон нийтэд мэдээлэх.
- Орон нутагт газар дээр нь ажиллан хэмжилт судалгаа хийж эвдэрсэн газрын хэмжээг нарийвчлан тодорхойлох;
- Хээрийн бичиглэлийг хавсралт хуудсаар бүртгэх;
- Фото зургаар баримтжуулах;
- Өндөр нарийвчлалтай агаарын зураг ашиглах замаар орхигдсон газрын тоо, талбайн хэмжээг тогтоох;
- Тухайн газарт олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хууль бус олборлогчыг тодорхойлох;
- Тооллогын ажилд, сумдын Багийн Засаг дарга, Байгаль орчны хяналтын байцаагч, Газрын даамал, Байгаль хамгаалагчдыг оролцуулах, мэдээлэл авах;
- Тооллогын үр дүнг мэдээллийн санд оруулах, түүнийг ашиглах нөхцөлийг хангах;
- Тооллогын үр дүнг хамруулсан эвдрэлд орсон газруудын нэгдсэн зураглал хийх;
- Тооллогын үр дүнг нэгтгэж тайланг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүлээлгэн өгөх.

Долоо. Зардал:

- Орон нутгийн төсөв;
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал;

Найм. Үр дүн, цаашид авах арга хэмжээ:

- Улсын хэмжээнд уул уурхайн зориулалтаар эвдэгдэж эзэнгүй орхигдсон газрын мэдээллийн сан шинэчлэгдэнэ.
- Эвдрэлд орсон газар тус бүрээр экологи, эдийн засгийн хохирол болон нөхөн сэргээх ажлын зардлыг холбогдох журмын дагуу тогтоох нөхцөл бүрдэнэ;
- Судалгааны үр дүнг үндэслэн нөхөн сэргээлт хийх газар, зардлыг үндсэн чиглэл төсөвтөө тусган хэрэгжүүлэх боломжтой болно.
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Ашигт малтмалын тухай хуулийн 39.3 "Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна." заалтууд хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
- Ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааны нөхөн сэргээлтийн гүйцэтгэлд орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас тавих хяналт сайжрах.
- Байгаль орчны нөхөн сэргээлт хийх, журам стандартыг мөрдүүлэх.
- Ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хууль бус үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг тогтоох, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх.
- Нөхөн сэргээлт хийлгүй орхигдсон талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР